




Уул уурхайн жишиг сургууль

Политехник коллеж

Илтгэлийн сэдэв: Тараах материал боловсруулахын ач
холбогдолыг дээшлүүлэхэд анхаарах нь

Илтгэл бичсэн: МХУЗ – ын багш Д.Дашдулам

Илтэлийн сэдэв: Тараах материал боловсруулахын ач

холбогдлыг дээшлүүлэхэд анхаарах нь

Түлхүүр үгс: Барш, суралцагч, тараах материал, онолын мэдлэг, суралт

Судалгааны үндэслэл: Орун үеийн суралтын зарчим нь оюутан, суралцагчдыг суралтын идэвхитэй субъект байх технологийг уруу шилжсэн. Үүнтэй уялдуулан барш хичээл, суралтаа зохион байгуулахдаа суралцагчдынхаа сурал үйл ажиллагааг идэвхжүүлэх нөлөөтэй янз бүрийн хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг өргөн хэрэглэх, тараах материалын чанар, үр дүнг ахиулах шаардлага урган гарсан билээ.

Тараах материалын ач холбогдлыг авч үзэхдээ зөвхөн оюутан, суралцагчдыг хөгжүүлэх тухай ярьдаг. Тэгэл үүний нөгөө талд баршийн хөгжил давахар явагдаж байдгийг анзаарах нь зүйтэй.

Хэрэгцээ, шаардлага:

Энэхүү сэдвийнхээ хүрээнд ерөнхий эрдмийн барш нар болон мэргэжлийн барш нар, ээлжит хичээлдээ тараах материалыг хэр зэрэг ашигладаг, ямар төрлийн тараах материал давамгайлдаг, тараах материалын хичээлд үзүүлэх ач холбогдлыг юу гэж үнэлдэг, тараах материалын хэрэгцээ, шаардлага ямар байгаа талаарх ойлголтыг авч үзэхийг зорьсон билээ.

Дэвшүүлж буй асуудал:

ТМБ – ын мэргэжлийн хичээлийн дагуу ашиглах онолын ном, мэргэжл тулс бүрээр хангалттай сайн байдаг боловч эдгээр ном, товхимолууд нь шинжлэх ухааны нэр томъёо, мэргэжлийн үг хэллэг давамгайлсан байдаг учир оюутан, суралцагчдад ашиглахад зарим талаар бархшээлтэй байдаг.

Нймээс барш, зарим шаардлагатай онолын хичээл дээр тараах материал боловсруулан гаргахын тулд мэргэжлийн холбогдолтой ном, сурал бичгийг судалж, түүн дээрээ сэдвийн боловсруулалт хийж маш их мэдлэг хуримтлуулах боломжтой.

Тараах материалаа боловсруулахдаа барш нар маань, оюутан, суралцагчдынхаа нас, сэтгэхүйн онцлогт тохируулан, хэлбэр хийц, харагдах байдал, хэмжээг нь хүртэл зөв тохируулах шаардлагатай.

Хичээл бүрийнхээ агуулгатай уялдуулан оюутан, суралцагчдынхаа мэдлэгийг ахиулах, батлах, сорих зорилгоор хийсэн тараах материалуудыг боловсруулах явцдаа барш өөрөө хөгжөөд зогсохгүй, шавь нараа хөгжүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

Судалгааны зорилго: Барш бүр тараах материалынхаа боловсруулалтыг чанартай болгосноор суралцагчдыг төдийгүй барш өөрийгөө мэргэжлийн түвшинд хөгжүүлэх боломж байгааг нээн илэрүүлэх, тараах материалын ач холбогдлыг ойлгуулах

Судалгааны зорилт:

- Хичээлийн үзүүлэн, тараах материалаар дамжуулан суралцагчид ойлголт, мэдлэгээ нэмэгдүүлэх, хөгжих боломжтойг судлах
- Тараах материал боловсруулахад баршид хөгжил явагддаг эсэхийг судлах

Онголын хэсэг

Суралцагчдыг идэвхижүүлэх, амжилттай сүргэн хүмүүжүүлэхийн тулд багш төрөл бүрийн хэрэгсэл, хэрэглүүр, хэрэглэгдэхүүнийг сонгон авч үзүүлэн таниулах үйлдлийг хийх шаардлагатай байдаг.

Үзүүлэн таниулах материалын арга нь суралцагчдад судалж буй юмс үзэгдлийн талаар үнэн зөв төсөөлөл, мэдлэг эзэмшүүлэхэд чиглэгддэг.

Нэгэн сургааль үгээс иш татвал:

“Надад хэлвэл би, мартана

Надад харуулбал би, тогтооно

Надаар хийлгэвэл би, сурна” гэсэн байдаг.

Дээрх сургаалиас үлгэрлэн бодвол багшийн хичээл, сургалтын арга нь ярих, тайлбарлах эсвэл үзүүлэх аргаар хязгаарлагдахгүй хамгийн чухал нь шавь нараараа аливаа зүйлийг сэтгэн бодуулах, учир шалтгааныг нь оллуулах, өөрийн биеэр хийж үзэхэд нь чиглэгдэх шаардлага өнөөгийн сургалтанд бий болоод удаж байна.

Сургалтын хэрэглэгдэхүүн бол хүүхдийг сүргэн хүмүүжүүлэх зорилгоор зориуд бэлдсэн зүйл, юмс зэрэг байна. Жишээ нь: Сүрх бичиг, тараах материал гэх мэт.

Эдгээр хэрэглэгдэхүүн нь нэг талаас суралцагчдын мэдрэхүйн эрхтэн болон хүсэл тэмүүлэлд шууд нөлөөлж, танин мэдэхүйн үйл ажиллагааг, нөгөө талаас багшийн ажлыг хөнгөвчилж өгдөг чухал зүйлсийн нэг.

Ерөнхий эрдмийн хичээлийн сургалтын гол хэрэглэгдэхүүн болсон сүрх бичгийг анги бүрээр агуулга, стандарттай нь уялдуулан төрөөс хангаж өгч байгаагаас гадна ерөнхий эрдмийн хичээл дээр ашиглах ном, сүрх бичгийн төрөл зүйл, зах зээл дээр багш бичгэнд төдийгүй суралцагчдад ч хангалттай сайн байдаг.

Харин мэргэжлийн хичээлүүдийн хувьд сүүлийн жилүүдэд ном, товхимол төрөл зүйлийн хувьд олширч байгаа хэдий ч оюутан суралцагчдад ойлгомж муутай, багш нар болон тухайн, тухайн мэргэжлийн хүрээний хүмүүст л чиглэгдсэн байдаг.

Иймд мэргэжлийн багш нар маань хичээлд ашиглах тараах материал, хэрэглэгдэхүүндээ өндөр ач холбогдол өгч, оюутан суралцагчдаа хөгжүүлэх зорилтын хүрээнд анхаарах ажиглах нь чухал болоод байна.

Сургалтын хэрэглэгдэхүүн нь аливаа зүйлийг тодорхой зорилгод хүргэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны нэг хэлбэр юм. Иймээс сургалтын хэрэглэгдэхүүн нь суралцагчдаас бүтээлч үйл ажиллагааг шаардсан байвал илүү үр дүнтэй болно.

Суралцагчдыг бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулах нь багшаас мэргэжлийн үр чадвар шаардсан ажил хэдий ч сургалтын зорилгодоо хүргэхийн тулд хичээлээ хэрхэн боловсруулсан байхаас ихээхэн хамааралтай байдаг.

Сургалтын хэрэгсэлдэхүүний үндсэн үүрэг:

- Тодорхой юмс үзэгдлийг шууд мэдрүүлэн мэдээлэл дамжуулах буюу танин мэдүүлэх
- Суралцагчдын авьяас, сонирхол, зориг мэдрэмжийг хөгжүүлэх буюу төлөвшүүлэх
- Мэдлэгийг бататгах, таамаглал дэвшүүлэн шийдэх, хянан шалгах зэрэг дидактикийн үүрэг гүйцэтгэнэ.

Үзүүлэн, тараах материалын төрлүүд:

- Биет үзүүлэн
- Зургалт үзүүлэн, тараах материал
- Онолын тараах материал
- Цахим үзүүлэн
- Хэрчмэл үзүүлэн
- Бичмэл үзүүлэн, тараах материал
- Бодит үзүүлэн
- Завар, хүснэгт, схемчилсэн үзүүлэн, тараах материал
- Бүдүүвч зураг
- Технологийн карт
- Түүвэр текст
- Асуулт даалгаварт тараах материал гэх мэт олон төрөлтэй.

Энэхүү шинэ зорилгыг уламжлалт хичээлийн технологи хэрэгжүүлж чадахгүй нь тодорхой. Иймээс багш нар бие дааж сэтгэдэг, хийж бүтээдэг хүнийг төлөвшүүлэхэд шавь төвтэй сургалтын аргыг хичээлдээ хэрэгжүүлэх нь чухал билээ.

Үчир нь шавь төвтэй сургалтын явцад багш нар суралцагчдаар эрэл хайгуул хийлгэх, мэдлэг бүтээлгэх, дүгнэлт хийлгэх, алдааг нь өөрсдөөр нь олгуулахаар оролдог. Мөн шавь төвтэй сургалтын явцад суралцагчийн сурах үйл ажиллагаа нь бие даасан, өөрийнхөө хэрэгцээ сонирхолд тулгуурлах боломжтой, хичээлийн туршид идэвхитэй оролцоног байх боломжтой байдаг.

Дээрх судалгааны дүнгээс харахад шавь төвтэй сургалтын явцад идэвхитэй хэрэгсэлдэг аргүүд болох үзүүлэн, тараах материал, хэлэлцүүлэг, аливааг хийж үзэх явцад болон бусдыг сонсох, хамтран ажиллах, мэдлэгээ солилцох зэрэг идэвхитэй үйл ажиллагааны явцад суралцагчдын аливаа мэдлэгийг ойлгох хувь өндөр байгаа нь харагдаж байна.

- Лекцийн үед – 5%
- Үнших явцад – 10%
- Сонсож харах үед – 20%
- Үзүүлэн, тараах материал – 30%
- Хэлэлцүүлэг – 50%
- Дарлал хийх явцад – 75%
- Бусдад зааж сургаж, хэрэгжүүлэх явцад – 90%

Сургалтын зорилго нь суралцагчдад шинэ мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх буюу эзэмшсэн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, зөв хандлагад сургадаг.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшийн сургалтын үйл ажиллагааны үндсэн үүргийг дараах 5 хэсэгт авч үздэг.

1. Сургалтын орчин, сургалт явуулах нөхцөл, шаардлагыг судлах
2. Хичээлийн төлөвлөгөө бэлтгэх
3. Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх
4. Сургалт явуулах буюу удирдах
5. Суралцахад дэмжих буюу хяналт тавих

Эдгээрээс "Сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх" гэсэн үүргийн гүйцэтгэлийн шалгуурт юу юу байдгийг анхааран үзье.

- ✓ Сургалтын гарын авлага, технологийн карт, үзүүлэн, тараах материалуудыг бэлтгэх
- ✓ Сургалтад хэрэглэгдэх барж хэрэгсэл, түүхий эд материалыг суралч нэг бүрт хүрэлцэхүйцээр бэлтгэх
- ✓ Анги танхим, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэх
- ✓ Холбогдох ажиглалтуудтай бүхий л зохион байгуулалтын талаар хамтран ажиллах

Манай сургуулийн хувьд мэргэжлийн багш нарт биет үзүүлэн, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлүүд нь сургалт явуулахад хангалттай байдаг.

Энэ хичээлийн жилд сургуулийн захиргаа ерөнхий эрдмийн Математик, Монгол хэл, Газар зүй, Эрүүл мэнд, Физик гэсэн хичээлүүдийн шинэ суралч бичгийг авч өрсөн нь сургалтаа явуулахад ихээхэн ач холбогдолтой байна.

Үчир нь суралч бичгээр дамжуулан багш, суралцагчдаа хөгжүүлэхээс гадна суралч бичгийн онолын агуулгатай холбогдуулан үзүүлэн, тараах материалаа боловсруулан хичээл, сургалтандаа үр дүнтэй ашигладаг билээ.

Суралцагчийн хэрэгцээнд тохируулан сургалтын хэрэглэгдэхүүнийг /тохируулан өөрчлөх/ баяжуулах, бэлтгэх

Суралцагч бүлийн хэрэгцээнд нийцсэн эсэхийг баталгаажуулах зорилгоор хэрэглэгдэхүүнд үнэлгээ хийх шаардлагатай. Хэрэглэгдэхүүнийг контекстжүүлэх гэдэг нь байшил, үнэлгээ болон сургалтын агуулгад нийцүүлэх зорилгоор сургалтын материалыг өөрчлөх буюу агуулгад тохируулга өөрчлөлт хийхийг хэлнэ.

Тухайлбал: Сургалт сургууль дээр эсвэл ажлын байранд зохион байгуулах бол хэрэглэгдэхүүнээ өөрсдийн агуулга, нөхцөл байдалд тохируулсан байх нь илүү зохиомжтой байх бөгөөд оролцогчдоод баримжаалахад дөхөмтэй болно. Хэрэглэгдэхүүнийг баяжуулахад дараах зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- Агуулгыг өөрчлөх – шинэ байшлыг илэрхийлэхийн тулд гарчигийг өөрчлөх
- Агуулгад нэмэлт буюу хасалт хийх
- Агуулгыг дахин боловсруулах
- Илүү материал нэмэх эсвэл орхигдсон зүйл байвал нэмж оруулах
- Дасгалуудыг өөрчлөх

Түүнчлэн өөрчилсөн буюу сайжруулсан сургалтын материалуудыг хянаж үзэх хэрэгтэй. Хар сайн болсон буюу зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг мараглах шаардлагатай. Тиймээс барш нар:

- ❖ Суралцагч ба бүлэг хамт олон тухайн хэрэглэгдэхүүнийг хэрхэн ашиглахыг ажиглаж тэмдэглэжээ хийх, хүндрэл учирсан эсвэл оролцоогчдоос уламжигдсан саналыг тэмдэглэн авах
- ❖ Сургалтын материалын хүртээмж, буюу ашиг тустай байгаа талаар суралцагч, бүлгээс асуулга авч саналуудыг нь хүлээж авах шаардлагатай.

Сургалтын материалыг эцэслэн цэгцлэх

Эхний хичээл эхлэхээс өмнө шаардлагатай бүх сургалтын материалуудыг бэлэн болсон эсэхийг барш баталгаажуулах шаардлагатай. Бэлэн болсон сургалтын материалуудаа холбогдох ажиглалтуудаар шалгуулж батлуулсан байх ёстой.

Судалгааны үр дүн:

"Тараах материал боловсруулахын ач холбогдолыг дээшлүүлэхэд анхаарах нь" илтгэлийн сэдвийнхээ хүрээнд "Асуулга авах", "Аричлалта авах", "Ажиглалт" – ын гэсэн судалгааны аргуудыг ашигласан.

5 асуумжтай судалгаа боловсруулж, нийт 20 барш, 100 оюутнаас судалгаа аван дүнл нэгтгэн боловсруулалт хийлээ.

Суралцагчаас авсан асуулга – 2019

1. Мэргэжлийн хичээлийн дагуу ном, товхимол уншаад шууд ойлгодог уу?

А. Шууд ойлгодог гэсэн хариултыг - 55%

Б. Ойгоход бархээлтэй байдаг гэсэн хариултыг - 44% нь сонгосон байгаа нь мэргэжлийн нэр томъёо, хүнд үг хэллэгтэй ном, гарын авлагыг ямар ч боловсруулалтгүйгээр хичээлдээ тогтмол ашиглах нь сургалтын зорилгыг хангаж чадахгүйгээс гадна ээлжит хичээл чанаргүй үр дүнгүй явагдана. Учир нь тухайн суралцагч тэмдэглэлээ хөтлөх боловч хичээлийн агуулгаас хэдий хэмжээний мэдлэг худимтлуулах нь тодорхой юмаа.

2. Барш боловсруулсан тараах материал дээр ажиглалахад хэр ойлгомжтой байдаг вэ?

А. Хялбар ойлгогддог - 65%

Б. Ойгоход дөхөмтэй байдаг - 34% гэж хариулсан байгаагаас баршийн боловсруулт хийсэн хэрэглэгдэхүүн, тараах материалын агуулга, суралцагчдын сурах хэрэгцээг хялбаршуулж, тэдэнд ямарч бархээлтэй ойлгогддог нь судалгаанд оролцогчдын 65% хялбар ойлгодог гэж хариулсан байгаагаас тодорхой байгаа ба хичээлийн үр дүнд ч сайнаар нөлөөлөх үзүүлэлт болно.

3. Ерөнхий эрдмийн хичээл дээр тараах материал ашиглуулах тохиолдол хэр зэрэг байдаг вэ?

А. Их - 26%

Б. Дунд зэрэг - 62%

В. Маш бага - 12%

А. Их - 31%

Б. Дунд зэрэг - 60%

В. Маш бага - 7%

4. Мэргэжлийн хичээл дээр тараах материал ашиглуулах тохиолдол хэр зэрэг байдаг вэ?

3, 4 – р асуултанд хариулсан байдаг харахад тараах материалыг сургалтандаа ерөнхий эрдмийн багш нар болон мэргэжлийн хичээлийн багш нар аль нь ашиглаж байгаа нь асуулгын дүнгээс харагдаж байгаа боловч эцсийн дүндээ ээлжит хичээлийнхээ агуулгын хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх нь, сургалтанд ач холбогдол үзүүлэхээр байна уу? гэдэг нь тодорхой бус байгаа юм.

5. Үзүүлэн тараах материал ашиглаж орсон хичээл дээр тухайн хичээлийг хэр зэрэг ойлгодог

БЗ?

А. Маш сайн ойлгодог – 50%

Б. Дунд зэрэг ойлгодог – 44%

В. Маш бага ойлгодог – 6% тус хариулсан байгаагаас харахад үзүүлэн, тараах материал ашиглаж орсон хичээл дээр суралцагчдын ихэнх буюу 50% маш сайн ойлгодог, 44% нь дунд зэрэг, дөнгөж 6% нь маш бага гэж хариулсан байгаагаас үзэхэд тараах материалаар дамжуулан суралцагч тухайн хичээлийн шинэ ойлголт мэдлэг, мэдээллийг хялбар ойлгохоос гадна давхар хөгжих боломжтой нь харагдаж байна.

"Барш" - Судалгааны асуулга – 2019

1. Ээлжит хичээлийн тараах материалын агуулгаар суралцагч хөгжих боломжтой юу?

А. Тийм – 17 багш

Б. Үгүй – 3 багш хариулсан ба судалгаанд нийт 20 багш хамрагдсанаас мэргэжлийн багш 10, ерөнхий эрдмийн багш 10 байсан. Асуулгын дүнгээс харахад тараах материалын агуулгаар суралцагч хөгжих боломжтой гэж 85% нь үзсэн байна. Иймд багшийн хичээлдээ боловсруулсан аливаа сургалтын хэрэгсэлдэхүүн, тараах материалаар дамжин суралцагчаа хөгжүүлэх бүрэн боломж байгааг хэрхэж болно.

2. Үзүүлэн, тараах материалын боловсруулалтаар дамжуулан, багш өөрийн мэргэжлийн дагуу хөгжих боломж байдаг уу?

А. Байдаг – 18 багш

Б. Байдаггүй – 2 багш хариулсан байгаагаас үзэхэд асуулгад хариулсан нийт багш нарын 90% нь багш өөрийн мэргэжлийн дагуу хөгжих боломж байдаг гэж хариулсан байгаа юм. Учир нь багш ээлжит хичээлдээ ашиглагдах тараах материалаа боловсруулахын тулд мэргэжлийн холбогдолтой ном, сурал бичгийг судлан шинжлэх шаардлага гардаг иймд багшийн мэдлэг ахих нь ойлгомжтой.

3. Багш та, тараах материалыг сургалтанд хэр ач холбогдолтой гэж үздэг вэ?

А. Их – 10 багш

Б. Дунд зэрэг – 10 багш

В. Маш бага гэсэн хариултыг

нагч багш, сонгоогүй байгаагаас харахад тараах материалыг сургалтанд хэр ач холбогдолтой багш бүр сайн мэддэг нь илэрхий байна.

4. Багш та, ээлжит хичээлийнхээ тараах материалыг боловсруулах явцад өөрийн мэргэжлийн дагуу онолын мэдлэгээ хэр зэрэг нэмэгдүүлдэг вэ?

А. Их – 12 багш

Б. Дунд зэрэг – 7 багш

В. Маш бага – 1 багш хариулсан.

Тараах материалын боловсруулгаар онолын мэдлэг их нэмэгддэг гэж 60% нь, дунд зэрэг гэж 35%, маш бага гэж 5% - тай хариулсан байгаагаас харахад тараах материалын боловсруулгаар дамжуулан багш нар мэргэжлийн дагуу онолын мэдлэгээ ахиулах боломжтойг баталж байна.

5. Багш та, тараах материалыг боловсруулах явцад ямар бэрхшээл тулгардаг вэ?

А. Санхүүгийн бэрхшээл - 6 буюу 30%

Б. Цаг хугацаа их орлог – 12 буюу 60%

В. Шаардлагад техник хэрэгсэл хангалтгүй – 12 гэж 60% - тай хариулсан

байгаагаас харахад цаг хугацаа их шаардсан, ажил болох нь тодорхой юм.

Дүгнэлт

Батшаа хөгжүүлэх, сургалтаа чанаржуулах ажлын хүрээнд хийгдэх алхам бүр энгийнээс эхлэх атлаа хүрэх үр дүн, ач холбогдол ямар чухал болохыг бид анхаарч ажиллах нь чухал билээ.

Тараах материалын боловсруулах ажлын хүрээнд 2017 – 2018 оны хичээлийн жилд ахлах багш М.Дэлгэрням, Б.Туяа нар "Хичээлийн хэрэглэгдэхүүн, тараах материалын боловсруулт" – ыг сайжруулах зорилгоор нийт багш нарын дунд уралдаан зарлахад эхний 1, 2, 3 - р байруудад ерөнхий эрдмийн багш нар орсон ба мэргэжлийн багш нарын идэвхи, оролцоо сул байсан байна.

Мөн тухайн хичээлийн жилд ахлах багш М.Дэлгэрням, арга зүйч багш М.Баярмаа, арга зүйч багш Ж.Норжмаа нар хамтран "Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам" – ын хэрэгжилтийг сайжруулах сургалт, хэлэлцүүлгийн үеэр багш нарын танхимын бүс цагийн ажлыг сургалтын албаны зүгээс үнэлэх үнэлгээ доогуур байгаа нь ажиглагдсан.

Би өөрийн илтгэлийн сэдвийн хүрээнд "Багц цагаар тооцох журам" – аас 8 – р заалт буюу "Сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт /сургалт болон биет үзүүлэлт, слайд, аудио ба видео бичлэг/ тооцох багц цаг нь сар бүр 0.3 хүртэл танхимийн эрхлэгч зурх эрхтэй гэж заасан байдаг.

Дээрх хэлэлцүүлгийн үеэр танхимын багц цагийн дэвтрээс 34 багшийн 8 – р заалтаар авсан кредитийг нэгтгэж үзсэн байгаагаас харавал энэ заалтаар бүтэн жилийн түрш хичээлд цуглуулсан 1 багшийн хамгийн өндөр кредит нь – 0.98 хамгийн бага нь 0.03 байгаагаас харахад журам дээр 0.3 хүртэл гэж заасан боловч сардаа 0.1 дээш тооцуулсан багш байхгүй байгаа юм.

Өөрийн хийсэн судалгааны дүнгээс дүгнэн үзвэл "Тараах материал боловсруулахад багш танд, ямар бэрхшээл тулгардаг вэ?" гэсэн асуултанд нийт багш нарын 60 % нь цаг хугацаа их ордог гэж хариулсан байгаа нь тараах материалын боловсруулалт нь тухайн багшаас цаг хугацаа шаардсан оюуны хөдөлмөр учир тараах материал, хичээлийн хэрэглэгдэхүүний боловсруулалт дээр сургалтын албаны зүгээс шаардлагад техник харгалснийн хүрэлцээг сайжруулах, үнэлгээ, урамшууллын аргаа ахиулах шаардлага байгаа нь харагдаж байна.

Миний бие энэхүү илтгэлээрээ дамжжиглан багшийн нар их хөдөлмөр, жижиг жижиг ажигбаруудын нийлбэр ба эдгээр дотроос сургалтын хэрэглэгдэхүүн бол аливаа сургалтын амин сүнс гэж үзэж байна.

Ээлжит хичээлийн чанар бол тухайн багш хичээлээ хэрхэн бэлтгэж, боловсруулсантай салшгүй холбоотой төдийгүй тараах материалынхаа боловсруулалтыг чанартай болгосоноор суралцагчдыг төдийгүй багш өөрийгөө мэргэжлийн түвшинд хөгжүүлэх боломжтой гэдгийг судлан тогтоохыг гол зорилгоо болгосон юмаа.

Мөн тараах материалын хэрэглээг зөвхөн танхимын сургалтанд хэрэглэдэг хэвшмэл арга барилгаасаа гарш, бид санах цаг болжээ

Жишээ нь: БНСУ – ын сургалтанд суралцагчийн гэрийн даалгаварыг тараах материал хэлбэрээр багш боловсруулан, тухайн даалгаварыг эцэг эх нь уншиж, танилцаад баталгаажуулж, гарын үсгээ зурдаг байна.

Багш хүний хөдөлмөрийн үр шим, ахиц амжилт бол багшийн мэргэжлийн мэдлэг чадвартай салшгүй холбоотой бөгөөд тараах материалын ач холбогдолыг багш бүр ойлгон ухаарч хичээл, сургалтандаа оновчтой ашиглан улмаар гарын авлага гарч хэмжээний мэдлэг, чадварыг ч хуримтлуулах боломж байгааг миний бие ажлын туршлагаараа анзаарсан юм.

Монгол хэлний хичээлийн хураанд 2000 оны эхээр "Монгол хэлний хичээлээр бодит чадвараа хөгжүүлэх нь" гэсэн суралцагчдад зориулсан "гарын авлага" гарч байсан ба одоо ч энэ гарын авлага "Бодит чадвар" нэртэйгээр боловсруулагдан гарч суралцагч багшаас хамааралгүй өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлээд удаж байна.

МБС – ын салбарт манай сургууль, туршлагатай олон сайхан мэргэжлийн багш нартай мэргэжлийн багш нараас маань ажлын туршлага, мэргэжлийн мэдлэг дээрээ үндэслэн "Хүнд машин механизмын засвар, ашиглалт, үргэлжлэлт" хичээлээр бодит чадвараа хөгжүүлэх нь" эсвэл "Барилгын цахилгаан монтаж хийх бодит чадвараа хөгжүүлэх нь" гэх мэтээр сургуулийнхаа "Брэнд бүтээгдэхүүн" – ийг гарган МБС – ын салбарт төдийгүй сургуульдаа соёлын үрийг тарина" гэдэгт миний бие маш их итгэлтэй байна.

Эцсийн дүндээ "Хөгжсөн багшаас, хөгжлийн ирээдүй болох чадвартай залуу боловсон хүчин бэлтгэгдэн гарах нь зүй ёсны хэрэг" Иймийн тул багш хүний хөгжлийн хөшүүрэг болсон ажлын үнэлэмж, хийж бүтээсэн зүйлийн нь бага гэлтгүй алдаа, оноог нь хэлж, дэмжин тусалж, урмын сайхан үсгээр усаалж байгаарай.

НОМЫН ЦАГААН БУНИЙГ ДЭЛГЭРҮҮЛЭГЧ, БАГШ НАРЫНХАА ОРОЙГҮЙ ЭРДИЙН АЖИЛД НЬ АМЖИЛТЫН ДЭЭЛИЙГ ЕРӨӨГ!

Ном зүй

1. "Багшийн ном" Ш.Ичинхорлоо, УБ 2008 он
2. "Орчин үеийн хичээлийн тухай өгүүлэх нь" Ш.Ичинхорлоо, УБ 2013 он
3. "Сургалтын арга зүйн шинэчлэл" Ш.Ичинхорлоо, УБ 2013 он
4. "Үйлийн судалгааны арга зүй" Өндөрхаан хот, 2009 он
5. "Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам" -- ын хэрэгжилтийг сайжруулах сургалт, хэлэлцүүлэгээс гарсан санал зөвлөмж ба түний баталгаажуулсан баримт бичиг ГСА, Сүмбэр сум, 2017 он
6. "Суралцагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь" сертификатын ажил, 2008
7. "Чадамжид суурилсан сургалтын гарын авлага" УБ 2013 он
8. "Чанартай сургалт - чадварлаг мэргэжилтэй ажилтан" УБ 2015 он